



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.05 № ГНАГ-2024/13-ШТА-НА-19
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.


Дүгнэлт

Ардчилсан намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сэлэнгэ аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (.....²⁶..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ШИНЭ БОДЛОГО-ШИНЭ ХӨГЖИЛ

“СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”

2024 он

ТОВЧ УТГА

НЭГ.ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ

- 1.1.Гэр бүл, хүүхэд
- 1.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- 1.3.Залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалал
- 1.4.Боловсрол
- 1.5.Эрүүл мэнд
- 1.6.Соёл урлаг
- 1.7.Хүний эрх, эрх чөлөө
- 1.8.Хэвлэл мэдээлэл

ХОЁР.ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

- 2.1.Хөдөлмөр эрхлэлт
- 2.2.Уул уурхай
- 2.3.Газар тариалан
- 2.4.Мал аж ахуй
- 2.5.Барилга, дэд бүтэц
- 2.6.Орон сууц
- 2.7.Эрчим хүч
- 2.8.Үйлдвэржилт
- 2.9.Төсөв, санхүү, татварын бодлого
- 2.10.Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа
- 2.11.Худалдаа үйлчилгээ

ГУРАВ.АЙМГИЙН ТӨВ, СҮХБААТАР ХОТЫН ХӨГЖИЛ ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 4.1.Төрийн албан хаагчид
- 4.2.Төрийн үйлчилгээний шуурхай байдал

ТАВ.АЮУЛГҮЙ ТАЙВАН ОРЧИН

ЗУРГАА.БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ


ДОЛОО.УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТ, БООМТЫН ХӨГЖИЛ

НАЙМ.ГАДААД ХАРИЛЦАА

ЕС.ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ШУДРАГА ЁС

ДЭД ХЭСЭГ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМ 2024 оны орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд **“ШИНЭ БОДЛОГО – ШИНЭ ХӨГЖИЛ”** хэмээх уриатайгаар мөрийн хөтөлбөрөө 9 бүлэг, 21 дэд сэдэвтэй боловсруулан та бүхэнд танилцуулж байна.



НЭГ.ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ

1.1.Гэр бүл, хүүхэд:

1.1.1.Өрхийн 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжиж ажиллана.

1.1.2.Хүүхдийг цахим халдлагаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр санал санаачилга гаргана.

1.1.3.Холбогдох байгууллагуудтай хамтран хүүхдийн зуслангуудын үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.1.4.Хүүхдийн хамгааллын хариу үйлчилгээг анхан шатанд үзүүлдэг хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэл буюу нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, бага насны болон хохирогч хүүхэдтэй ажиллах зэрэг мэргэшсэн дэмжих багийг бодлогоор дэмжиж ажиллана.

1.1.5.Хүүхэд хамгаалах чиглэлийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

1.1.6.Хурдан морины уралдаан, морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уяач нь уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.1.7.Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авна.

1.1.8.Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” дэд хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.1.9.Гэр бүлийн гишүүн бүрт гэр бүлийн боловсрол олгох “Монгол гэр бүл” боловсролын дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд:

1.2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.2.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах, нийгмийн үр дүнтэй оролцоог дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвийг аймагт байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

1.2.4.Эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин нөхцөлийг бий болгоно.

1.2.5.Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж, өөрчлөх асуудлыг шийдвэрлэнэ.

1.2.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тогтмол орлого олох нөхцөл бололцоог хангаж, бүх талын туслалцаа үзүүлнэ.

1.2.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээнд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхийг бодлогоор дэмжинэ.

1.2.8.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхдэд зориулсан нарсан ойд төрийн мэдлийн сувилалын газар байгуулна.

1.3.Залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалал:

1.3.1.Залуучуудын хөгжлийн "Community center" байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.

1.3.2.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, илүү үр дүнтэй хэлбэрээр шинэчлэн зохион байгуулна.

1.3.3.Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.


1.3.4.Ахмад настанд зориулсан сэргээн засах, эмчилгээ, сувилгааны цогцолбор төвийг байгуулж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

1.3.5.Ахмадын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулж, үйлчилгээ хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.6. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр Сүхбаатар суманд ахмадын өргөө байгуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

1.3.7.Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх "СЭЛЭНГЭ STEAM" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/

1.3.8.Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.



1.4.Боловсрол:

1.4.1.Ахлах ангийн сурагчдыг ажил хөдөлмөрт бэлтгэх зорилгоор “Зуны хөтөлбөр”-ийг сум, сургууль бүрийн онцлог байдлыг түшиглэн зохион байгуулна.

1.4.2.Ард иргэд, аж ахуйн нэгж, компаниуд, хандивлагчдын идэвхтэй оролцоо, дэмжлэгийг хангах замаар боловсролыг дэмжих “Орон нутгийн сан”-г байгуулж, нээлттэй, олон нийтийн хяналттай, ил тод, үр дүнтэй зарцуулж хэвшүүлнэ.

1.4.3.Багшийг хөгжүүлэх “Сайн багш-Хөгжсөн сурагч” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.4.4.”Цахим-Сэлэнгэ” хөтөлбөрийг хэрэгжүүлж, цахим технологи, ухаалаг сургалтыг сургалтын байгууллага бүр дээр хүртээмжтэй нэвтрүүлнэ.

1.4.5.Политехник коллежууд болон насан туршийн боловсролын төвийн хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх арга замаар ард иргэдийн амьдрах ухааны сургалтын үр нөлөөг нэмэгдүүлнэ.

1.4.6. Шат шатны төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр “Багшийн хөгжлийн ордон”-г шинээр байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.4.7.Багш, сурагч солилцооны хөтөлбөр болон боловсролын бусад чиглэлээр өндөр хөгжилтэй улс орнуудын туршлагыг судалж, идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

1.4.8.Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтод бүлгийн хүүхэд залуучууд, иргэдийн сурч хөгжих “Тэгш боломж” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.4.9. Холбогдох байгууллагуудтай хамтран Политехник коллежуудыг түшиглэн шинжлэх ухаан технологи, инноваци, гарааны бизнес /startup/-ийн инкуватор төвийг байгуулна.

1.4.10.Политехник коллежуудын үйл ажиллагааг бүх талаар дэмжин инновацид суурилсан бренд бүтээгдэхүүнүүдийг бий болгоно.

1.4.11.Политехник коллежуудыг түшиглэн ахлах сургууль байгуулах асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.

1.4.12.Үдийн цай хөтөлбөрийг орон нутгийнхаа аж ахуйн нэгж, байгууллагууд хамтран аймаг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах үйл ажиллагааг зохион байгуулж, эрүүл аюулгүй хоол хүнсээр сурагчдаа үйлчлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.4.13.Гадаадын их дээд сургуульд жил бүр 10-аас доошгүй шилдэг сурагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.4.14.Сэлэнгэ аймагт Хөдөө аж ахуйн чиглэлийн их дээд сургуулийн салбарыг нээх асуудлыг судалж, сумдын болон бүс нутагтаа хөдөө аж ахуйн болон инженер техникийн ажилтнаар хангаж ажиллах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.15.Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар сум бүрт бага насны хүүхэд нэг км радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжийг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

1.4.16.Сургуулийн автобусаар үйлчилж, хүүхэд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцлийг бүрдүүлж, камержуулалтыг өргөжүүлнэ.

1.4.17.Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын "цөм" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлж, орон нутаг, иргэний нийгмийн байгууллага, гэр бүлийн оролцоог өргөжүүлнэ.

1.4.18.Дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах төслийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

1.4.19.Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нөхцөл орчныг бүрдүүлж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

1.4.20.Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний санаа бодлыг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгах зорилгоор насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг дэмжинэ.

1.5.Эрүүл мэнд:

1.5.1.Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулна.

1.5.2.Аймгийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.

1.5.3.Хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулж, эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах зорилт тавьж ажиллана.

1.5.4.Сэлэнгэ аймгийн хэмжээнд хүүхдийн эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын байгалийн үзэсгэлэнт газарт сувиллыг шинээр барьж, ашиглалт оруулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

1.5.5.Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулна.

1.5.6.Архидалт, хар тамхи, мансууруулах бодист донтох, амиа хорлолтын шалтгаан, сэтгэл зүйн өвчлөлийг эрт илрүүлэх тасгийн үйл ажиллагааг өргөжүүлж, сайжруулахад бодлогоор дэмжиж ажиллана.

1.5.7.Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг оновчтой зохион байгуулж, үр дүнг тооцдог болгоход онцгой анхаарч ажиллана.

1.5.8.Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, сувилагч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.

1.5.9.Эмчийн чадавх, эмчилгээний үр дүнг үнэлэх, цахим систем ажиллуулж, өрсөлдөөнд суурилсан тусламж үйлчилгээг үзүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

1.5.10.Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5.11.Эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.

1.5.12.Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, үржүүлэх, тарих үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

1.5.13.Эмийн хэрэглээ, эрүүл аюулгүй байдлын хяналтыг сайжруулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллана.


1.5.14.Аймгийн хэмжээнд нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

1.5.15.Аймгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл, аюулгүй ээлттэй орчныг бүрдүүлж, эрүүл амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэн эрт илрүүлэлтийг оновчтой тасралтгүй зохион байгуулж, “80+” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.5.16.“Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд “Элэг бүтэн монгол”, “Эрүүл шүд”, “Умайн хүзүүний хавдаргүй монгол” болон бусад арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1.5.17.Аймгийн хүн амын дунд тэргүүлэх өвчлөл, эндэгдлийг тогтоож, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, эрт илрүүлэг үзлэг оношилгоонд тогтмол хугацаанд хамрагддаг хэвшлийг бий болгоно.

1.5.18.Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол зохион байгуулснаар эмч, эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдлыг ханган ажиллана.



1.6.Соёл урлаг, спорт:

1.6.1.Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртээл болгох ажлыг эхлүүлнэ.

1.6.2.Аймгийнхаа соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.

1.6.3.Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулна.

1.6.4.Мэргэжлийн урлагийн байгууллага, залуу уран бүтээлчдийн уран бүтээлээ олны хүртээл болгох, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.6.5.Сайн дурын уран сайханчид болон урлагийн холбоодын үүсгэл санаачилгыг дэмжинэ.

1.6.6.Үндэсний өв соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, сурталчилж өвлүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн үндэстэн, ястны язгуур урлагийн наадмыг зохион байгуулж ардын авьяастнуудыг тодруулна.

1.6.7.Түүх, соёлын агуулга бүхий контентыг хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

1.6.8.Сэлэнгэ аймгийн биеийн тамир, спортын салбарт аюулгүй ажиллагааны талаар шаардлагатай стандартуудыг нэвтрүүлж ажиллана.

1.6.9.Спорт цогцолбор, усан бассейн, сургалтын төв, чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх барилга байгууламж, дэд бүтцийг бий болгох төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

1.6.10.Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцоход бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

1.6.11.Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.6.12.Аймгийн хэмжээний томоохон суурин газруудад дугуйн зам барих төслийг хэрэгжүүлнэ.

1.6.13.Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, чөлөөт цагийн клубуудын үйл ажиллагааг дэмжинэ.

1.6.14.Сүхбаатар, Мандал, Сайхан суманд хүүхэд залуучуудын спорт соёл амралтын хүрээлэн барих ажлыг судалж, хэрэгжүүлнэ.

1.6.15.Сүхбаатар, Мандал суманд орчин үеийн шийдэлтэй стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай, Ерөө сумын Бугант тосгонд хоккейн талбай, бусад сумдын онцлогт тохирсон спортын байгууламж барих санаачилга гарган, санхүүжилтийг улс, аймгийн төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.

1.6.16.Чөлөөт өрсөлдөөний зарчимд нийцүүлэн мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудад нэмэлт орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар хамтарч ажиллана.

1.6.17.Төрийн өмчийн оролцоо бүхий соёлын байгууллагуудад менежментийн шинэчлэл хийж, бие даасан байдлыг сайжруулна.

1.7.Хүний эрх, эрх чөлөө:

1.7.1.Монгол хүн өмчтэй байх, өмчдөө бүрэн эрхт эзэн нь байх нөхцөлийг сайжруулна.

1.7.2.Ардчиллын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүх шатны сонгуульд саналаа өгөх, Улсын Их Хуралд сонгогдсон гишүүд, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулан саналаа илэрхийлэхийг дэмжиж ажиллана.

1.7.3.Хүний заяагдмал эрхийг хамгаалах, иргэдэд хүний эрхийн талаар ойлголт өгөх, сурталчлан таниулах үйл ажиллагааг дэмжинэ.

1.8.Хэвлэл мэдээлэл:

1.8.1.Орон нутгийн эрэн сурвалжлах сэтгүүл зүй, чөлөөт, олон ургалч хэвлэл мэдээллийн эрх чөлөөний баталгааг дээшлүүлж, хэвлэл мэдээллийн хараат бус бие даасан байдлыг хангана.

ХОЁР.ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

2.1.Хөдөлмөр эрхлэлт:

2.1.1.Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шууд худалдаалах төвийг сумдад байгуулах, борлуулалтын сүлжээг бий болгох асуудлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэнэ.

2.1.2.Салбарын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгоно.

2.1.3.Баялаг бүтээгчдээ дэмжиж, Сэлэнгэчүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.4.“Өрх бүр баялаг бүтээгч” дэд хөтөлбөрийг сумдуудад үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.1.5.Аймаг, сумдуудын бизнес хөгжүүлэх төвөөр дамжуулан бизнес эрхлэгчдийг дэмжинэ.

2.1.6.Аймгийн хэмжээнд орон сууцжуулах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх замаар барилгын салбарт ажиллагсдыг бодлогоор дэмжинэ.

2.1.7.Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.

2.1.8.Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.

2.1.9.Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг хүлээн зөвшөөрнө.


2.1.10.Сэлэнгэ аймгийн хэмжээнд ядуурлын түвшнийг улсын дунджаас бууруулах үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.11.Эрдэс баялаг, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.2.Уул уурхай:

2.2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн ашигт малтмалыг олборлож, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох боломжтой үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бодлого баримтална.

2.2.2.Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандаа хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгоно.



2.2.3. Аюулгүй ажиллагааны хариуцлагыг чангатган уул уурхайн хайгуул болон олборлолт, хаалтын аюулгүйн үйл ажиллагааг зохицуулах хууль журмыг хэрэгжүүлнэ.

2.2.4. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын хүрээнд алтны хууль бус олборлолт, наймааг таслан зогсоох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.2.5. Аймгийн нутаг дэвсгэрт нөхөн сэргээх шаардлагатай газруудад иргэн, аж ахуй нэгж, олон нийтийн оролцоо, Олон Улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.6. Аймгийн “Уул уурхайн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд бичил уурхай эрхлэгчдийг бизнесийн бусад салбарт шилжин ажиллахад нь бодлогоор дэмжиж ажиллана.

2.2.7. Эрдэс баялгийн салбарт ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэн, дэлхийн эдийн засгийн ногоон шилжилттэй уялдуулсан мега төслүүдийг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн эрчимтэй өсөлтийг бий болгоно.

2.2.8. Бичил уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулан хууль бус олборлогчдод тавих төрийн хяналтын тогтолцоог сайжруулна.

2.2.9. Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрэн хариуцахад хяналт тавина.

2.2.10. Уурхайн үйл ажиллагааны хяналт, нөхөн сэргээлт, хаалтын стандартыг олон улсын жишигт хүргэж, дүйцүүлсэн нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулна.

2.2.11. Олборлох салбарын ил тод байдлын санаачилга /ОСИТБС/-ын аймгийн салбар зөвлөлийг хуулийн дагуу шинэчлэн байгуулна.

2.2.12. Сэлэнгэ аймагт ашиглалтын лиценц эзэмшиж буй уул уурхайн ашиглалт, нийгмийн хариуцлагад тавих хяналтыг өндөржүүлж, орон нутаг дахь үр өгөөжийг дээшлүүлнэ.

2.2.13. Ховор металиас бусад төрлийн ашигт малтмалыг шинээр хайх, олборлох үйл ажиллагааг шинээр эхлүүлэхгүй байна.

2.3.Газар тариалан:

2.3.1.Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ус, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийн хангамжийг сайжруулж, нэгжээс авах ургацыг дээшлүүлнэ.

2.3.2.Хүлэмжийн аж ахуй, дуслын усалгаанд шаардлагатай нар, салхины сэргээгдэх эх үүсвэрээр хангах төсөл хэрэгжүүлнэ.

2.3.3.Өрх, байгууллага бүр хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, шинэ ногооны нэр төрөл, хангамжийг сайжруулна.

2.3.4.Газар тариалангийн бүс нутаг, сумдад услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжиж ажиллана.

2.3.5.Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.3.6.Үр тариа болон ургамал хамгаалах химийн бодис, бордоо, био бэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

2.3.7.Өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлнэ.

2.3.8.Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.


2.3.9.Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

2.3.10.Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжиж ажиллана.

2.3.11.Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.3.12.Сэлэнгэ аймагт хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлж, "Органик хүнс" хөтөлбөр боловсруулж, мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг ханган, экспортлох бодлого баримтална.

2.3.13.Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын хүнсний бүтээгдэхүүний лаборатори байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллана.



2.3.14.Төв суурин газрын нийтийн орон сууцны оршин суугчдад хүнсний хэрэгцээгээ хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор дөрвөн улирлын төвлөрсөн хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, ногоо тариалах газрын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх бодлого баримтална.

2.3.15.Мэдээллийн технологийг ашиглан мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.

2.3.16.Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр аймгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3.17.Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр Солонгос, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг орон нутагтаа нутагшуулах ажлыг зохион байгуулна.

2.3.18.Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бий болгож, аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх замаар найдвартай хүнс нийлүүлэгч аймаг болох бодлого баримтална.

2.3.19.Малчдын малаа маллах дундын бэлчээрийг баталгаажуулж, ашиглалтын хариуцлагыг нэмэгдүүлж, малчдын эрх ашгийг хамгаална.

2.3.20.Суурин болон хагас суурин маллагаатай эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх журам, зохицуулалтын бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.3.21.Тариалангийн талбайд ойн зурвас байгуулж, хөрсний элэгдэл, малын хөлөөс хамгаална.

2.3.22.Газар тариалангийн үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийж, баталгаат сортын үрийн хангамж, ургамал хөрс хамгаалалт, услалтын систем барих зэрэг агро техникийн цогц арга хэмжээг дэмжинэ.

2.4.Мал аж ахуй:

2.4.1.Малын эмч нарын ур чадварыг дэмжих замаар нэгж малд ногдох мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна.

2.4.2.Мал эмнэлгийн байгууллагын санаачилгад үндэслэн "Малын эмчилгээ, сувилгааны төв"-ийг төв, суурин газраас зайтай, бэлчээрийн бүс нутагт малчдад ойрхон байгуулах санаачилгыг дэмжинэ.

2.4.3.Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.

2.4.4. Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэх мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4.5. Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг хөгжүүлнэ.

2.4.6. Аймгийн хэмжээнд малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулж төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлнэ.

2.4.7. Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг чанартай болгож, хяналтыг сайжруулна.

2.4.8. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх хяналтыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулж, эрүүлжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4.9. Малаас гарч буй түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг бодлогоор дэмжинэ.

2.4.10. Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.

2.4.11. Уламжлалт мал, аж ахуйн гаралтай түүхий эд ноос, ноолуур, арьс шир, махыг малчдын оролцоотой анхан шатны түүхий эдийн тордолгооны цэгт бэлтгэн өндөр түвшний технологийн үйлдвэрт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хамтран ажиллана.

2.4.12. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлнэ.

2.5. Барилга, дэд бүтэц:

2.5.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг нийт салбарын хөгжилтэй уялдуулан нэгдмэл болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.5.2. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр өгөөжтэй, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан шинэ технологийн халаалт, дэд бүтцийн системийг нэвтрүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.5.3. Нийтийн орон сууцны ашиглалтын хүрээнд төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллага болон СӨХ-дын түншлэлд шилжүүлэх журмаар засвар, үйлчилгээний, инженерийн хангамжийн асуудлуудыг өмчлөгч

өөрөө хариуцах чадамжийг бэхжүүлж, төрийн оролцоог хязгаарлах бодлого хэрэгжүүлнэ.

2.5.4.Амины орон сууцны болон хуучин орон сууцны дулаан алдагдлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.

2.5.5.Гэр хорооллын дэд бүтцийг шийдэж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Таны хашаа” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.5.6.Барилгын салбарт хөрөнгө оруулалтын цогц механизмыг нэвтрүүлнэ.

2.5.7.Барилгын салбарт ажиллагсдын эрүүл мэнд, санхүүгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

2.5.8.Аймаг, сумдын төвийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийн ажлыг дэмжиж, эрчимжүүлнэ.

2.5.9.Барилга, байгууламжийн насжилтыг тогтоож мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, дахин төлөвлөх ажлыг эхлүүлнэ.

2.5.10.Орон нутагт хотжилтыг дэмжих зорилгоор Сүхбаатар, Сайхан, Мандал зэрэг сумдад барилгын материалын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.

2.5.11.Сэлэнгэ аймагт сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заал, бассейн, хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагыг мөрдүүлнэ.


2.5.12.Шинээр баригдаж буй барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам шат бүхий хэрэгсэл суулгана.

2.5.13.Эдийн засгийн өсөлтийн суурь болсон дэд бүтэц (зам тээвэр, эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо)-ийн хөрөнгө оруулалтыг хувийн, төсвийн, болон төр, хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл, боломжийг идэвхтэй ашиглана.

2.5.14.Аймгийн төв болон томоохон сумдад “Гудамж” төслийг үргэлжлүүлэн, авто замын уулзварыг шинэчлэх ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бодлого баримтална.

2.5.15.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр дээрх авто замын болон аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээний танилцуулга гаргана.

2.5.16.Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.



2.5.17.Шинэ суурьшлын бүс болон сумын төвийн шинэчлэлийн хүрээнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц бүхий барилга байгууламж барих ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэнэ.

2.5.18.Төв суурин газрын хүн амыг эрүүл ахуй, чанарын шаардлагад нийцсэн усаар хангаж, дэд бүтцийг сайжруулна.

2.5.19.Сэлэнгэ аймагт барилгын салбарт баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

2.5.20.Сайхан суманд барилгын материал үйлдвэрлэх цогцолбор төвийг шинээр байгуулах асуудлыг төр, хувийн хэвшлийн бусад байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

2.6.Орон сууц:

2.6.1.Хүн амыг орон сууцжуулах зорилтын хүрээнд дараах чиглэлээр орон сууцны бодлого хэрэгжүүлнэ. Үүнд:

-“Тогтвортой орлого бүхий орон сууц” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймаг, сумын төвүүдэд 20-100 айлын орон сууцыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байршилтай уялдуулан хүн амын зорилтот бүлэгт тааламжтай нөхцөлөөр бүтээн байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжинэ;

2.6.2.Бага, дунд орлоготой иргэдэд зориулж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумдын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулж, дэд бүтэцжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

2.7.Эрчим хүч:


2.7.1.Сүхбаатар хотыг цахилгаан эрчим хүчний хоёрдогч эх үүсвэрээр хангах асуудлыг судалж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

2.7.2.Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг барих төр хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.7.3.Сумдын дулааны станц, уурын зуухны өмчлөлийн асуудлыг хянаж, үр дүнг тооцон олон нийтэд мэдээлнэ.

2.7.4.“Шинэ зууны малчин” хөтөлбөр хэрэгжүүлж, малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангахад бодлогоор дэмжинэ.

2.7.5.Сэлэнгэ аймагт баригдаж буй 50 мВт-ийн дулааны цахилгаан станцын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.



2.8.Үйлдвэржилт:

2.8.1.Нүүрс, төмөрлөгийн үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлогоор дэмжлэг ажиллана.

2.8.2.Аймаг орон нутагт өрсөлдөх чадвар бүхий түүхий эд, эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин ажиллана.

2.8.3.Эдийн засгаа уул уурхайн салбараас хараат байдлаас гаргах зорилгоор хөнгөн-хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, эдийн засгийн бусад салбаруудын өсөлтийг дэмжих бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад уламжилна.

2.8.4.Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, олон улсын чанар, стандартыг нутагшуулж, экспортлох цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

2.8.5.Орон нутагтаа стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох жимс жимсгэнэ, элсэн чихэр, ургамлын тосны хангамжийг нэмэгдүүлэх хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн санаачилгыг дэмжинэ.

2.8.6.Сэлэнгэ аймагт загас, загасан бүтээгдэхүүн нөөшлөх үйлдвэрийг барьж байгуулах хувийн хэвшил, иргэдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.8.7.Импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

2.8.8.Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бий болгож аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх замаар найдвартай хүнс нийлүүлэгч аймаг болох бодлого баримтална.


2.8.9.Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гаднын байгууллагуудын хөрөнгө оруулалт, зээл, тусламжид хамруулах бодлого баримтална.

2.8.10.Экспортын чиг баримжаатай хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн кластерийг аймгийн түвшинд хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.8.11.Төрөөс аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд баримтлах бодлогын хүрээнд орон нутагтаа томоохон үйлдвэрлэлийн төслүүдийг эхлүүлнэ.

2.9.Төсөв, санхүү, татварын бодлого:

2.9.1.Орон нутгийн төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.



2.9.2.Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.

2.9.3.Хуримтлалыг бий болгох сургалт мэдээллийн бодлогыг хэрэгжүүлж иргэдийн банкин дахь хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.9.4.Татварын байцаагч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлийг баримтална.

2.9.5.Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

2.9.6.Аймгийн хэмжээнд үнэт цаасны брокерын үйл ажиллагааг тогтвортой ажиллуулахыг дэмжинэ.

2.9.7.Малын тоо толгойн албан татварыг бууруулах нөхцөл, боломжийг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авна.

2.9.8.Түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашигласан төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авна.

2.10.Жижиг, дунд бизнес, бизнесийн дархлаа:

2.10.1.Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гарах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

2.10.2.Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин, бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулна.

2.10.3.Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжих орон нутгийн бизнес, брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор "СЭЛЭНГЭ ХӨГЖИЛ" ОНӨААТҮГ-ыг байгуулна.

2.10.4.Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг болгоно.

2.10.5.Эдийн засгийн түншлэл, бүс нутгийн чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, гадаад худалдааг хөгжүүлнэ.

2.10.6.Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хамтран ажиллана.

2.10.7.Жижиг дунд үйлдвэрлэлийн дархлааг тогтвортой байлгах зорилгоор аймгаас борлуулалтын зах зээлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

2.11.Худалдаа үйлчилгээ:

2.11.1.Хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний аймгийн хэрэгцээг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.11.2.Хүн амын хүнсний чанар, шим тэжээлийг сайжруулж, тэнцвэртэй, эрүүл хооллолтын зохистой дадлыг хэвшүүлнэ.

2.11.3.Байгалийн болон бэлчээрийн мал аж ахуйн гаралтай органик хүнс, хүнсний нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжиж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.11.4.Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны орчныг либералчилж, эко, ногоон, органик шошготой бүтээгдэхүүнийг олшруулан сав баглаа, боодлыг улсын нэгдмэл стандарттай болгоно.

2.11.5.Хот, суурин газрын хүнсний нийтийн хэрэглээний малыг зөвхөн үйлдвэрийн аргаар нядалж боловсруулах стандартыг бүрдүүлж, энэ чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.11.6.Хэрэглэгчдийн оролцоог нэмэгдүүлж, лабораториудын үйл ажиллагааг чанаржуулна.

2.11.7.Хүнсний гол хэрэгцээ болох мах, ногооны зориулалтын зоорийг барих, мах, хүнсний ногооны хадгалалтыг сайжруулах асуудлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.11.8.Хүнсний захуудад баримталдаг ариун цэвэр, аюулгүй байдлын стандартыг чанд мөрдүүлж ажиллана.


2.11.9.Суурь хэрэгцээний хүнсийг аймагтаа үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийн санал, санаачилгыг дэмжинэ.

2.11.10.Мэдлэг, технологийн дэвшил, инновац шингэсэн орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2.11.11.Жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалах болон хүлэмжийн газар олгох, ашиглахад уян хатан бодлого баримталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

ГУРАВ.АЙМГИЙН ТӨВ, СҮХБААТАР ХОТЫН ХӨГЖИЛ:

3.1.Аймгийн төвийн 8 дугаар багт шинэ суурьшлын бүсийг байгуулж, дэд бүтцийг байгуулах хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.



3.2.Аймгийн төвд Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх парк, цэцэрлэгт хүрээлэнг байгуулах төслийг зохих газраар шийдвэрлүүлнэ.

3.3.Сүхбаатар суманд баригдаж буй 50 мВт-ын дулааны цахилгаан станцыг бүх талаар дэмжиж, хөрөнгө оруулагчийг дэмжиж ажиллана.

3.4.Аялал жуулчлалын салбарыг орон нутгийн оролцоотойгоор хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

3.5.Сүхбаатар сумын газрын төлөвлөлт, олголтын орчинд реформ хийж, газар олгох, ашиглах, эзэмших, өмчлөх үйл ажиллагааг ил тод болгоно.

3.6.Иргэдийн өмчлөлийн газрын дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг төрийн нэгдмэл бодлоготой уялдуулан байгуулна.

3.7.Сүхбаатар сумын болон бусад сумдын үерийн хамгаалалтын даланг шинэчилж, иргэдийг гамшгаас хамгаалах, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8.Хог хаягдлын менежментийн хүрээнд дахин боловсруулах цэгийг нэмэгдүүлэх, ялган боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулах асуудлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

3.9.Сүхбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу бичил хороолол байгуулах, дэд бүтцэд холбон хөгжүүлнэ.

ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ИРГЭДИЙН ОРОЛЦОО:

4.1.Төрийн албан хаагчид:

4.1.1.Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.

4.1.2.Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна.

4.1.3.Аймагтаа засаглалын зөв механизмыг бүрдүүлж, мөчлөг дагасан сонгуулийн бодлогоос татгалзаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, төрийн албаны мерит зарчмыг баримтална.

4.1.4.Аймагтаа засаглалын эрүүл орчныг бий болгож, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл, сонирхол татах орчныг бүрдүүлэх бодлого баримтална.

4.1.5.Орон нутгийн хөгжлийн ялгааг арилгаж, тэнцвэртэй хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Аймгийн 5 бүсийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан бодлогын баримт бичгийг шинэчилнэ.

4.1.6.Төрийн хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

4.1.7.Төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл, ажлын байранд тавигдах шалгуур, шаардлагыг тодорхой болгож, нам дагасан томилгооноос салгана.

4.1.8.Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

4.1.9.Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд нээлттэй, ил тод ажлын тайлангийн сонсгол хийдэг ажлыг тогтмолжуулна.

4.1.10.Төрийн албаны мерит зарчмыг хадгална.

4.2.Төрийн үйлчилгээний шуурхай байдал:

4.2.1.Цахим өргөдөл, гомдлын төвийн үйл ажиллагааг сэргээж, үйл ажиллагааг сайжруулна.

4.2.2.Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг тэлэн орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.

ТАВ.АЮУЛГҮЙ ТАЙВАН ОРЧИН:

5.1.Кибер халдлагатай тэмцэх, иргэний цахим мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

5.2.Гамшиг, аюулаас хамгаалах аймгийн бүтэц бий болгож, үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын болон орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.


5.3.Авлигын эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих орчныг бүрдүүлэх санал дэвшүүлж, хамтран хэрэгжүүлнэ.

5.4.Аймаг, сумын эрсдэл бүхий газрууд, автобусны буудлуудыг камержуулж, цагдаагийн байгууллагатай шууд, хялбар байдлаар холбогдох тоноглол хийсэн аюулгүй бүс бий болгох ажлыг дэмжинэ.

5.5.Инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын стандартыг хангуулна.

5.6.Төрийн тусгай албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.

5.7.Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгцээтэй мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.



ЗУРГАА.БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ:

6.1.Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн нутаг дэвсгэрийн 66.9 хувь нь цөлжилтөд нэрвэгдсэнийг сааруулах, хамгаалалтын зурвасыг шинээр нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

6.2.Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.

6.3.Байгаль орчны хүний нөөцийн бодлогыг аймгийн хэмжээнд боловсруулж ажиллана.

6.4.Байгалийн нөөц, баялгийн хүртээмжийг тэгш шударга, нээлттэй байхад хяналт тавьж ажиллана.

6.5.Ус, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах цогц дэд хөтөлбөр боловсруулна.

6.6.Тусгай хамгаалалттай газар нутгийг судалгааны үндсэн дээр нэмэгдүүлж, онцлог эко системийн үйлчилгээ, үнэ цэнийг өсгөнө.

6.7.Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулах, хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

6.8.Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна.

6.9.Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрөл олгох үйл явцаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлнэ.

6.10.Суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, газар чөлөөлөх, усны нөөц бохирдох, хомсдохоос сэргийлэх чиглэлээр ажлыг зохион байгуулна.

6.11.Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөж, шаардлага хангасан ундны ус хэрэглэдэг хүн амын тоог нэмэгдүүлнэ.

6.12.Сэлэнгэ мөрөнд урсацын тохируулгатай, олон зориулалтын цуваа усан сангууд байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулна.

6.13. Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт болон орон нутгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход чиглүүлэх бодлого баримтална.

6.14. Аймгийн аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын хүрээнд Тур бааз, Тур оператор компаниудын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, стандартыг мөрдүүлнэ.

6.15. Орон нутгийн иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамтран ажиллана.

6.16. Аялал жуулчлалын салбарт ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэхэд анхаарч, сургалтад хамруулах асуудлыг бодлогоор дэмжинэ.

6.17. Сэлэнгэ аймагт аялах, жуулчлах эрэлтийг нэмэгдүүлэх, эргэлтийг нь сайжруулах зорилгоор эвент арга хэмжээг зохион байгуулна.

6.18. Орон нутгийн иргэдийн амьдралд эерэгээр нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

6.19. Аймгийн төвөөс “Номт” амралтын газар хүртэлх авто замын шинэчлэлийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

6.20. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилга, хөтөлбөр, арга хэмжээг бодлогоор дэмжинэ.

6.21. Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт орших “Солдат толгой”-д түүх дурсгалын цогцолбор байгуулах саналыг холбогдох газраар шийдвэрлүүлж, хэрэгжүүлнэ.

ДОЛОО.УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТ, БООМТЫН ХӨГЖИЛ:


7.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг орон нутагт хэрэгжүүлж, аймгийн хил хамгаалах болон шалган нэвтрүүлэх байгууллагуудын хэвийн, тогтвортой үйл ажиллагааг хангана.

7.2. Хилийн бүс, зурваст нэвтрэх зөвшөөрлийг хил орчмын нутаг дэвсгэрт нутаглаж буй иргэдэд олгож, байгаль, цаг агаар хүндэрсэн тохиолдолд малчдад туслалцаа үзүүлнэ.

7.3.Хилийн боомтод үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нарын ажиллах орчныг бүрдүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.

7.4.Хилийн застав, боомтод үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нарын гэр бүлийн гишүүдийг сургалт, дамжаанд хамруулах талаар анхаарч ажиллана.

НАЙМ.ГАДААД ХАРИЛЦАА:



8.1.Оросын Холбооны Улс болон бусад орнуудтай байгуулсан найрсаг хамтын үйл ажиллагааг эрхэмлэж, гадаад харилцааг эдийн засагжуулахад идэвхтэй байр суурь баримтална.

8.2.Хамтын ажиллагаатай улс орнуудын хүрээг өргөжүүлж, гадаад харилцааг бодлогыг хэрэгжүүлнэ.

8.3.Аймгаа гадаадад сурталчлан таниулах, гадаад улс дахь монгол угсаатнуудад монгол хэл, түүх, соёл, өв уламжлалыг сэргээхэд дэмжлэг үзүүлнэ.

ЕС.ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ШУДАРГА ЁС

9.1.Хууль, шүүхийн байгууллагын албан хаагчдын ёс зүй, зан харилцаанд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох бодлогыг хамтран хэрэгжүүлнэ.

9.2.Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүрэг болох иргэдийн аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах арга ажиллагааны хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлнэ.

9.3.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донтогч болсон иргэнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бодлого баримтална.

9.4.Үзэл бодол, яс үндэс, нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг гэр бүлийн орчин, ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

9.5.Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

9.6.Нийтэд тустай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүртээмжийг сайжруулах бодлого баримтална.

9.7.Гамшиг, аюулаас хамгаалах мэргэжлийн байгууллага болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, хамтарч ажиллана.

9.8.Аймаг, сумын нутгийн удирдлагын байгууллагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

9.9.Иргэд гарын үсэг цуглуулж, тодорхой асуудлыг хөндөж дэвшүүлсэн тохиолдолд аймаг, сумын ИТХ шууд авч хэлэлцэх боломжийг бий болгоно.

9.10.Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэнэ.

9.11.Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.

9.12.Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

9.13.Орон нутагт хэрэгжүүлэх аливаа төсөл, хөтөлбөр, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ил тод, нээлттэй болгоно.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО